

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

НИЙСЛЭЛ

2016 ОНЫ 12-Р САР (Мониторингод нийслэл, дүүргийн нийт 10 ЗДТГ хамрагдав.)

Шилэн дансны тухай хуулиар улсын болон орон нутгийн төсвийн байгууллагууд 28 төрлийн мэдээллийг тодорхой хугацааны давтамжтайгаар нийтэд ил тод болгох ёстой. Эдгээрээс зургааг сонгон авч нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газар (ЗДТГ)-ууд 2016 оны 12 дугаар сард мэдээллээ хэрхэн ил тод болгосон байдлыг ажиглав.

АЖИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ДҮН

ЗДТГ-ууд Төрийн санд бүртгэгдсэн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй ХУДАЛДАН АВАЛТ, ГҮЙЛГЭЭНИЙ мэдээллийг бүрэн гүйцэд ил тод болгохгүй байна.

Энэ удаагийн мониторингоор ЗДТГ-уудын ил тод болгосон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллийг Сангийн яамны Төрийн сангийн 2016 оны 12 дугаар сарын дансны хуулгатай харьцуулж үзэв.

Энэхүү харьцуулалтаас харахад Багахангай, Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар дүүргүүдийн ЗДТГ-ын үзүүлэлт харьцангуй сайн буюу дунджаар нийт ил болгох мэдээллийн 96 хувийг, харин Улаанбаатар хотын ЗДТГ зөвхөн 21 хувийг ил болгожээ.

100.0%

Баянзүрх дүүрэг, Багахангай дүүрэг

96.3%

Хан-Уул дүүрэг

89.5%

Сүхбаатар дүүрэг

80.0%

Налайх дүүрэг

73.3%

Багануур дүүрэг

72.7%

Баянгол дүүрэг

56.7%

Сонгинохайрхан дүүрэг

43.2%

Чингэлтэй дүүрэг

20.8%

Улаанбаатар

5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээнд ХОЛБОГДОХ ШИЙДВЭР болон 2016 оны ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ил тод байдал маш хангалтгүй байна.

0%



Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээ тус бүрт холбогдох шийдвэр (хуулийн 6.10-р заалт)-ийг ЗДТГ-ууд огт нийтлээгүй.

20%



2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (хуулийн 6.1.1-р заалт)-г зөвхөн Багахангай, Сүхбаатар дүүргүүдийн ЗДТГ ил болгожээ.

5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, гүйлгээний мэдээллийг нийтэлсэн байдал

5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт (мэдээллийн тоо)

67

Чингэлтэй дүүрэг

50

Сонгинохайрхан дүүрэг

41

Баянзүрх дүүрэг

37

Баянгол дүүрэг

15

Налайх дүүрэг

12

Сүхбаатар дүүрэг

11

Багануур дүүрэг, Хан-Уул дүүрэг

0

Улаанбаатар, Багахангай дүүрэг

5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ (хуулийн 6.4.4-р заалт) зэргийг ЗДТГ-уудын 80% буюу 8 нь нийтэлжээ. Чингэлтэй дүүргийн ЗДТГ хамгийн олон буюу 67 мэдээлэл нийтэлсэн бол Улаанбаатар хот, Багахангай дүүргийн ЗДТГ мэдээлэл огт нийтлээгүй байна.

Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээний тоо

49

Баянгол дүүрэг

46

Хан-Уул дүүрэг

44

Сүхбаатар дүүрэг

39

Баянзүрх дүүрэг

33

Улаанбаатар

32

Чингэлтэй дүүрэг

23

Сонгинохайрхан дүүрэг

11

Багануур дүүрэг

8

Багахангай дүүрэг

7

Налайх дүүрэг

Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ тус бүрийн гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр бүхий 49 мэдээллийг Баянгол дүүргийн ЗДТГ нийтэлжээ. Харин хамгийн цөөн мэдээллийг Налайх, Багахангай дүүргүүд нийтэд мэдээлсэн байна.

АШИГ ЛАСАН МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас
- ЗДТГ-уудын цахим хуудас

- ЗДТГ-уудын мэдээллийн самбар
- Сангийн яамны Төрийн сангийн дансны хуулга

ННФ-аас Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран мониторинг хийж дүнг сар бүр мэдээлж байна. Дүнг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.